

БАТЛАВ
САНХҮҮ, АР ТАЛЫН АЛБАНЫ
АВТОБААЗЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА
3.НАРАНБААТАР
СЭТН0431

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Өвлийн дугуйнд тавигдах шаардлага:

- 1.Тээврийн хэрэгслийн өвлийн резинэн дугуй нь 2024 үйлдвэрлэгдсэн шинэ дугуй байна.
- 2.Өвлийн улиралд температурын нөлөөнд орж хөлдөхгүй байна.
- 3.Хээ нь олон ойр зайтай /балруулан хээтэй/ байна.
- 4.Материалын чанар алдагдаагүй гадаргуутай барьцалдах чадвар сайн байна.
- 5.Резинэн дугуй нь хадгалалт болон тээвэрлэлтээс үүдэн геометр хэлбэр хэмжээний алдагдалгүй, хэвийн, шинэ байна.
- 6.Резинэн дугуйны үзүүлэлт, үйлдвэрийн баталгаа, ашиглалтын заавар, жингийн үзүүлэлт бүхий техникийн баримт, гэрчилгээ, "Үйлдвэрийн баталгаат шошго"-той байна.
- 7.Зүтгэх зориулалт бүхий хөндлөн, дөрвөлжин хээтэй.
- 8.Резинэн дугуйны чийгшлийг хадгалах баглаа боодолтой байна.
- 9.Өвлийн резинэн дугуйг дараах размер тоо ширхгээр нийлүүлнэ.

д/д	Өвлийн дугуйны размер	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	205/65/16	ш	8
2	205/70/15	ш	4
3	215/75/15	ш	8
4	215/60/17	ш	12
5	205/65/15	ш	92
6	215/60/16	ш	12
7	215/65/16	ш	36
8	215/70/16	ш	100
	Нийт дүн		272

Өвлийн дугуйны тодорхойлолт:

Өвлийн резинэн дугуйг бага температур болон цас, мөстэй замд зориулан хийсэн байдаг. Түүний резиний хольц нь хүйтний улиралд хүч дамжуулахад (шүдний тусламжтай газрыг маажин) хангалттай уян налархай шинж чанартай байна. Өвлийн дугуйг M+S (Mud and Snow) буюу шавар болон цас гэсэн тэмдгээр тэмдэглэдэг. Өвлийн дугуйны газартай харьцах эргэлтийн талбайн хээ болон бүтэц нь цас болон шавартай замд зориулагдсан учир хэвийн дугуйнаас илүү явалт болон зүтгэлтийн шинж чанарыг үзүүлэх ёстой. Мөн түүний хээ нь хэвийн дугуйнаас өргөн, хээ хоорондын зай томтой байхаас гадна хээний гүн нь бас гүн суусан байх шаардлагатай. Өвлийн дугуй нь зуны дугуйтай харьцуулахад түүний хээ нь хавьгүй олон байхаас гадна нийт хээний харьцах ирмэгийн урт зуны дугуйны харьцах ирмэгийн уртаас хамаагүй их байснаар сул газарт илүү барьцалдах шинж чанарыг

үзүүлдэг. Зуны дугуйг бодвол өвлийн дугуй нь тухайн тээврийн хэрэгслийн гэрчилгээнд заасны дагуух хурдны индекс бүхий дугуйнаас бага хурдны индекстэй дугуйг хэрэглэж болдог. Гэхдээ энэ тохиолдолд "M+S" гэсэн тэмдэгтэй дугуйг ашиглах зүйтэй (дөрвөн улирлын дугуй үүнд орохгүй). Хурдны дээд хязгаар бүхий хурдны замтай бусад улсуудад ийм тэмдэглэгээг хурдны замын дээд хязгаарын тэмдэглэгээ болгон наах тохиолдол ч бас бий. Хамгийн түгээмэл өвлийн дугуйны хурдны Т ангиллаас (190 км/ц хүртэл) илүү хурдны ангиллын U, H, V (цөөн тохиолдолд W=270 км/ц хүртэл) тэмдэглэгээтэй дугуйнуудыг бүх төрлийн хэмжээстэйгээр санал болгодог байна.

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:
АВТОБААЗЫН АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР,
ЦАГДААГИЙН ДЭСЛЭГЧ



А.БУЯНБАТ